



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймаг дахь Политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/137/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дундговь аймаг 2026 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Т.Батсайхан Утас: 70592225 Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn</p> <p>Аудитыг гүйцэтгэсэн: Azure Хүлүг Аудит ХХК Утас: 70110090 Цахим хаяг: audit@azure.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
3.1 Албан шаардлага	8
3.2 Зөвлөмж	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сүм
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
ДАРГА Ю.ЦОЛМОН ТАНАА**

2026.02.25

№

53

танай

-ны №

-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймаг дахь Политехник коллежийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймаг дахь Политехник коллежийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 276,466.7 мянган төгрөгөөр өссөн байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолоор үндсэн хөрөнгө акталсантай холбоотой хөрөнгийн дансны үлдэгдэл 177,100.8 мянган төгрөгөөр буурчээ. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний

4826050180

олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 57 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 91.3 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	79,968,346.40	183,205,760.92
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	79,968,346.40	183,205,760.92
31210	Төгрөг	79,968,346.40	183,205,760.92
31211	Төрийн сангийн харилцах	17,735,002.48	183,205,760.92
31218	Ахмадын сангийн харилцах	62,233,343.92	-
33	АВЛАГА	56,765,496.00	95,049,480.43
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,069,666.00	1,178,546.01
33101	Цалингийн авлага	1,069,666.00	1,069,666.00
33102	НДШ-ийн авлага	-	84,603.01
33103	ХАОАТ-ын авлага	-	24,277.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	4,033,000.00	4,033,000.00
33500	Бусад авлага	51,662,830.00	89,837,934.42
33510	Байгууллагаас авах авлага	37,645,500.00	54,400,604.42
33520	Хувь хүмүүсээс авах авлага	14,017,330.00	35,437,330.00
35	БАРАА МАТЕРИАЛ	440,091,118.40	499,419,866.46
35100	Түүхий эд материал	7,477,870.00	7,491,270.00
35110	Тусгай зориулалттай материал	6,718,800.00	6,718,800.00
35130	Эм боох материал	759,070.00	772,470.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	976,300.00	976,300.00
35400	Хангамжийн материал	431,636,948.40	490,952,296.46
35410	Бичиг хэргийн материал	2,803,500.00	399,200.00
35420	Аж ахуйн материал	259,688,679.90	265,812,727.96
35430	Сэлбэг хэрэгсэл	700,000.00	1,450,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,470,000.00	2,660,000.00
35450	Барилгын засварын материал	3,575,000.00	3,575,000.00
35460	Хүнсний материал	3,339,845.00	8,471,295.00
35470	Бусад хангамжийн материал	159,059,923.50	208,584,073.50
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	576,824,960.80	777,675,107.81
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,600,532,178.97	9,423,431,380.31
39200	Биет хөрөнгө	8,889,044,178.97	8,711,943,380.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,590,264,577.00	10,590,264,577.00
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(2,018,460,788.60)	(2,272,961,317.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	120,702,930.00	120,702,930.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(120,702,930.00)	(120,702,930.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,374,508,922.75	1,362,289,805.38
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(1,276,394,473.90)	(1,228,140,756.88)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	209,564,236.28	257,132,610.47
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(207,909,585.51)	(200,290,689.59)
39214	Бусад үндсэн хөрөнгө	254,755,786.29	232,853,854.29
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(185,609,192.69)	(177,805,974.29)
39217	Номын фонд	148,324,697.35	148,601,271.33
39300	Биет бус хөрөнгө	711,488,000.00	711,488,000.00
39301	Программ хангамж	17,330,000.00	1,080,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Программ хангамж	(17,330,000.00)	(1,080,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	711,488,000.00	711,488,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	9,600,532,178.97	9,423,431,380.31
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	10,177,357,139.77	10,201,106,488.12
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	65,607,665.53	27,223,094.40
41300	Өглөг	65,607,665.53	27,223,094.40
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	7,435.59	-
41313	ХАОАТ-ын өглөг	7,435.59	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	65,594,433.64	26,037,298.10
413203	Түлш халаалтын өглөг	64,861,273.64	-
413205	Тээвэр, шатахууны өглөг	4,200.00	4,200.00
413207	Албан томилолтын өглөг	250,000.00	-
413208	Хоолны өглөг	-	5,175,455.00
413210	Урсгал засварын зардлын тооцоо	-	9,610,100.00

413213	Бусад зардлын өглөг	478,960.00	11,247,543.10
41360	Бусад өглөг	5,796.30	1,185,796.30
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,180,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	5,796.30	5,796.30
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	65,607,665.53	27,223,094.40
51	Засгийн газрын хувь оролцоо	10,111,749,474.24	10,173,883,393.72
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,601,279,404.95	2,601,279,404.95
511001	Засгийн газрын оруулсан капитал засгийн газрын сан	2,601,279,404.95	2,601,279,404.95
51200	Хуримтлагдсан үр дүн	5,912,152,397.51	5,974,286,316.99
51210	Өмнөх үеийн үр дүн	5,912,152,397.51	5,912,152,397.51
51220	Тайлант үеийн үр дүн	-	62,133,919.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,598,317,671.78	1,598,317,671.78
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	10,111,749,474.24	10,173,883,393.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	10,177,357,139.77	10,201,106,488.12

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,607,163,289.14	3,976,185,950.00
1310	Улсын төсвөөс	2,950,427,700.00	3,233,874,890.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,950,427,700.00	3,233,874,890.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	79,138,289.14	77,303,660.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	79,138,289.14	77,303,660.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	577,597,300.00	665,007,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	577,597,300.00	665,007,400.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	98,927,343.00	130,917,390.00
1200	Нийтлэг татварын бус орлого	98,927,343.00	130,917,390.00
120009	Бусад нийтлэг татварын бус орлого	51,504,083.00	-
120010	Борлуулалтын орлого (цэвэр) - ТӨҮГ	-	15,726,700.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	42,313,260.00	82,964,650.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	5,110,000.00	32,226,040.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,706,090,632.14	4,107,103,340.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,725,384,527.15	4,044,726,194.50
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,456,536,627.15	3,887,583,769.33
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,935,492,294.30	2,211,959,018.00
210101	Үндсэн цалин	1,135,761,414.30	1,274,869,890.00
210102	Нэмэгдэл	626,223,687.00	753,038,889.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	71,090,000.00	74,953,303.00
210104	Урамшуулал	102,417,193.00	109,096,936.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	240,943,145.21	268,730,921.86
210201	Тэтгэврийн даатгал	164,484,904.86	184,605,653.59
210202	Тэтгэмжийн даатгал	19,547,396.23	22,591,848.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,817,683.89	10,785,465.72
210204	Ажилгүйдлийн даатгал	8,839,338.68	10,319,580.10
210205	Эрүүл мэндийн даатгал	38,253,821.55	40,428,374.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	564,921,319.42	569,139,491.19
210301	Гэрэл, цахилгаан	32,496,798.20	38,875,423.86
210302	Түлш, халаалт	496,080,347.00	496,080,347.00
210303	Цэвэр, бохир ус	36,344,174.22	34,183,720.33
2104	Хангамж, бараа материалын зардал	49,427,689.30	75,181,984.74
210401	Бичиг хэрэг	7,959,890.00	9,551,750.00
210402	Тээвэр, шатахуун	13,232,249.10	14,841,632.80
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,111,982.40	26,239,780.00
210408	Бараа материал акталсны зардал	11,123,567.80	24,548,821.94
2105	Нормативт зардал	73,948,515.00	107,555,554.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	637,950.00	961,300.00
210502	Хоол, хүнс	73,310,565.00	106,594,254.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,651,740.00	36,832,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,737,980.00	1,463,200.00
210604	Урсгал засвар	29,913,760.00	35,369,700.00
2107	Томилолт, зочны зардал	250,000.00	-
210702	Дотоод албан томилолт	250,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	37,966,960.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	37,966,960.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	559,901,923.92	580,216,939.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	109,614,279.35	108,190,978.50
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	138,539,721.00	155,039,038.40
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	311,747,923.57	316,986,922.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	268,847,900.00	157,142,425.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	268,847,900.00	151,595,390.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	128,787,900.00	33,925,390.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	128,560,000.00	117,670,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,500,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	5,547,035.17
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,547,035.17
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	3,725,384,527.15	4,044,726,194.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(19,293,895.01)	62,377,145.50
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	243,226.02
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	243,226.02
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	243,226.02
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(19,293,895.01)	62,133,919.48

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,608,293,289.14	3,977,185,950.00
1310	Улсын төсвөөс	2,950,427,700.00	3,233,874,890.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,950,427,700.00	3,233,874,890.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,268,289.14	78,303,660.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	80,268,289.14	78,303,660.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	577,597,300.00	665,007,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	577,597,300.00	665,007,400.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	46,873,583.00	-
1200	Нийтлэг татварын бус орлого	46,873,583.00	-
120009	Бусад нийтлэг татварын бус орлого	46,873,583.00	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,655,166,872.14	3,977,185,950.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,589,750,019.66	3,834,468,805.48
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,320,902,119.66	3,677,326,380.31
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,935,478,536.00	2,212,073,353.60
210101	Үндсэн цалин	1,135,747,654.00	1,274,899,622.59
210102	Нэмэгдэл	626,223,687.00	753,123,492.01
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	71,090,000.00	74,953,303.00
210104	Урамшуулал	102,417,195.00	109,096,936.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	240,943,145.21	268,732,901.86
210201	Тэтгэврийн даатгал	164,484,904.84	184,605,653.59
210202	Тэтгэмжийн даатгал	19,547,396.23	22,591,848.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,817,683.89	10,785,465.72
210204	Ажилгүйдлийн даатгал	8,839,338.68	10,319,580.10
210205	Эрүүл мэндийн даатгал	38,253,821.57	40,430,354.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	565,947,300.00	634,000,764.83
210301	Гэрэл, цахилгаан	32,496,798.20	38,875,423.86

210302	Түлш, халаалт	496,080,347.00	560,941,620.64
210303	Цэвэр, бохир ус	37,370,154.80	34,183,720.33
2105	Нормативт зардал	75,852,000.00	106,087,989.00
210502	Хоол, хүнс	75,852,000.00	106,087,989.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	66,306,640.00	45,262,670.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	889,970.00
210602	Тавилга	18,220,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	17,510,880.00	18,613,100.00
210604	Урсгал засвар	30,575,760.00	25,759,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	37,966,960.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	37,966,960.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	436,374,498.45	373,201,741.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	214,953,575.45	216,693,128.72
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	221,420,923.00	156,508,612.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	268,847,900.00	157,142,425.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	268,847,900.00	151,595,390.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	128,787,900.00	33,925,390.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	128,560,000.00	117,670,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,500,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	5,547,035.17
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,547,035.17
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	3,589,750,019.66	3,834,468,805.48
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	65,416,852.48	142,717,144.52
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,644,600.00	39,479,730.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	27,644,600.00	39,479,730.00
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	27,644,600.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,644,600.00	39,479,730.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	27,644,600.00	39,479,730.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(27,644,600.00)	(39,479,730.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	37,772,252.48	103,237,414.52
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	42,196,093.92	79,968,346.40
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	79,968,346.40	183,205,760.92

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,601,279,404.95	1,598,317,671.78	5,931,446,292.52	10,131,043,369.25
Тайлант үеийн үр дүн	-	-	(19,293,895.01)	(19,293,895.01)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,601,279,404.95	1,598,317,671.78	5,912,152,397.51	10,111,749,474.24
Тайлант үеийн үр дүн	-	-	62,133,919.48	62,133,919.48
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,601,279,404.95	1,598,317,671.78	5,974,286,316.99	10,173,883,393.72

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Улсын төсвөөс	3,346,776,800.00	3,312,178,550.00	34,598,250.00
Орон нутгийн төсвөөс	665,007,400.00	665,007,400.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,011,784,200.00	3,977,185,950.00	34,598,250.00
Ажиллагчидтай холбогдсон зардал	2,588,107,700.00	2,480,806,255.46	107,301,444.54
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,300,540,200.00	2,212,073,353.60	88,466,846.40
Цалин	1,402,606,100.00	1,274,899,622.59	127,706,477.41
Цалингийн тусгай нэмэгдлүүд	897,934,100.00	937,173,731.01	(39,239,631.01)
Нийгмийн хамгааллын шимтгэл	287,567,500.00	268,732,901.86	18,834,598.14
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	218,551,300.00	207,197,501.73	11,353,798.27
Эрүүл мэндийн даатгалын хураамж	69,016,200.00	61,535,400.13	7,480,799.87
Бараа, үйлчилгээний урсгал зардал	1,270,080,100.00	1,330,908,936.10	(60,828,836.10)
Тогтмол зардал	665,007,400.00	634,000,764.83	31,006,635.17
Гэрэл цахилгааны зардал	49,105,300.00	38,875,423.86	10,229,876.14
Түлш, халаалтын зардал	561,829,300.00	560,941,620.64	887,679.36
Цэвэр, бохир усны зардал	28,313,200.00	34,183,720.33	(5,870,520.33)
Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	758,669,100.00	696,908,171.27	61,760,928.73
Хоол	148,778,000.00	106,087,989.00	42,690,011.00
Бусад бараа үйлчилгээний зардал	397,181,000.00	154,459,784.80	242,721,215.20
Ном, хэвлэлийн зардал	559,800.00	519,800.00	40,000.00
Хичээл сургалт үйлдвэрлэлийн дадлагын зардал	-	156,508,612.30	(156,508,612.30)
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	-	18,613,100.00	(18,613,100.00)
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	37,966,960.00	(37,966,960.00)
Урсгал засварын зардал	58,553,900.00	25,759,600.00	32,794,300.00
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	153,596,400.00	151,595,390.00	2,001,010.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	-	39,849,900.00	(39,849,900.00)
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,547,035.17	(5,547,035.17)
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	4,011,784,200.00	3,811,715,191.56	200,069,008.44
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		17,735,002.48	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		183,205,760.92	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 27,684.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 5,592.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэх, 22,091.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж өглөө.

3.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Насжилт өндөртэй 5,102.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т (*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*); Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т (*нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах*), 20.2.5-т (*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*) гэж заасныг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Насжилт өндөртэй авлага барагдуулах арга хэмжээг авч, тооцоо нийж баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 2: Хоолны ордерт олговол зохих материалын нэг бүрийн үнийг дутуу бөглөсөн, өдрийн норм хэмжээнд засвар хийсэн дотуур байрны хүүхдийн хоолыг Засгийн газрын тогтоолд зааснаас 490.1 мянган төгрөгийн илүү дүнгээр зарцуулсан зэрэг зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т (*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*), 13.6-т (*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна*), Засгийн газрын 2025 оны 254 дугаар тогтоол 2-т (*Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах дунд болон ахлах ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6300 (зургаан мянга гурван зуу) төгрөгөөр, бага ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6000 (зургаан мянга) төгрөгөөр тус тус тогтоосугай*) гэж заасныг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүнсний материалын тайланг холбогдох хууль, тогтоомжийн дагуу бэлтгэх, дотуур байрны хоолны зардлыг батлагдсан нормын дагуу тооцож, зарцуулах зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3.2 Зөвлөмж

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Жолоочийн тооцооны хуудсанд ирсэн явсан цаг, спидометрийн эхний, эцсийн заалтыг, явсан километр болон зарцуулсан 1,711.1 мянган төгрөгийн шатахууны мэдээллийг бүрэн бөглөөгүй мөн санхүүгийн тэмдгээр баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг 13.1-т (*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*), *Сангийн сайдын 2017 оны 347 дугаар "Маягт, заавар батлах тухай" тушаалыг тус тус хэрэгжүүлээгүй байна*) гэж заасныг мөн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн тооцооны хуудсан ирсэн, явсан цаг, спидометрийн заалт, явсан километр болон зарцуулсан шатахууны мэдээллийг бүрэн бөглөж ажиллах.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 2: Үндсэн хөрөнгийн түүвэр тооллогоор 14,080.4 мянган төгрөгийн өртөгтэй 13 ширхэг хөрөнгийн коджуулалт хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т (*Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно*), 20 дугаар зүйлийн 20.2.3. (*"холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;*) гэж заасныг мөн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өмч хамгаалах зөвлөл хөрөнгийн ашиглалт хадгалалтад хяналт тавьж ажиллах, хөрөнгийн коджуулалт хийх.

3. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 3: Хувь хүнтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулж татвар суутгаагүй олгосон ажлын хөлсийг суутган төлөгчийн хувь хүнд олгосон 6,300.0 мянган төгрөгийн орлогод ногдуулан суутгасан албан татварын тайланд тусгаагүй.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т (*хувиараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх, зуучлалын үйл ажиллагаа эрхэлж олсон орлого*), 25 дугаар зүйлийн 25.4-т (*Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж илгээнэ*) гэж заасныг мөн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлж, олгосон урамшууллаас татварыг суутгаж, татварын тайланд тайлагнаж ажиллах.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 100 хувийг залруулагдаагүй алдаа, зөрчил эзэлж байна. Нийт 27,684.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь 11,892.8 мянган төгрөгийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчил, 15,791.5 мянган төгрөгийн нийцлийн аудитын зөрчил байна. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 11,892.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 28,554.4 мянган төгрөгөөр бага байгаа тул “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Насжилт өндөртэй авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	5,102.7	-	-	1	5,102.7	-	-	-	-
Хоолны ордерт олговол зохих материалын нэг бүрийн үнийг дутуу бөглөсөн, өдрийн норм хэмжээнд засвар хийсэн дотуур байрны хүүхдийн хоолыг Засгийн газрын тогтоолд зааснаас илүү дүнгээр зарцуулсан зэрэг зөрчил илэрлээ.	1	490.1	-	-	1	490.1	-	-	-	-
Хувь хүнтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулж татвар суутгаагүй олгосон ажлын хөлсийг суутган төлөгчийн хувь хүнд олгосон орлогод ногдуулан суутгасан албан татварын тайланд тусгаагүй.	1	6,300.0	-	-	-	-	1	6,300.0	-	-
Дүн	3	11,892.8	-	-	2	5,592.8	1	6,300.0	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль										
Үндсэн хөрөнгийн түүвэр тооллогоор 13 ширхэг хөрөнгийн коджуулалт хийгээгүй байна.	1	14,080.4	-	-	-	-	1	14,080.4	-	-
Жолоочийн тооцооны хуудсанд ирсэн явсан цаг, спидометрийн эхний, эцсийн заалтыг, явсан километр болон зарцуулсан шатахууны мэдээллийг бүрэн бөглөөгүй мөн санхүүгийн тэмдгээр баталгаажуулаагүй.	1	1,711.1	-	-	-	-	1	1,711.1	-	-
Дүн	2	15,791.5	-	-	-	-	2	15,791.5	-	-